





- |   |  |                |
|---|--|----------------|
| 1. Танилцсан: Тамгын газрын захирал                                   |  | А.Энхжин       |
| 2. Хянасан: Тамгын газрын ҮААХ-ийн захирал                            |  | Г.Нямсүрэн     |
| Тамгын газрын ЗХНХ-ийн төсвийн ахлах мэргэжилтэн                      |  | О.Бадамцоо - 2 |
| 3. Боловсруулсан: Тамгын газрын ҮААХ-ийн худалдан авалтын мэргэжилтэн |  | Ц.Урантуяа     |

**МОНГОЛБАНКНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**  
(2017 оны 2 дугаар улирлын байдлаар)

Монголбанкны 2017 оны бараа, ажил үйлчилгээ, худалдан авах төлөвлөгөөг Ерөнхийлөгчийн 2017 оны 01 дүгээр 27-ны өдрийн А-26 дугаар тушаалаар баталж, төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” болон “Монголбанкинд бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

Монголбанкны 2017 оны тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ нийлүүлэгчийн нэр хаяг зэрэг мэдээллийг “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 7, 8 дагуу хавсралтын дагуу боловсруулан, Монголбанкны цахим хуудсанд байршуулан, тухай бүр шинэчилж байна.

**Нэг. Нээлттэй тендер шалгаруулалтын худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тухай**

Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг өдөр тутмын сонин, Монголбанкны цахим хуудсан, олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тухай бүр мэдээлсэн болно. Монголбанк 2017 онд дор дурдсан 3 нээлттэй тендер, 1 зөвлөх үйлчилгээний тендер, 1 хязгаарлагдмал тендер шалгаруулалт зохион байгууллаа.

**1. Монголбанкинд 250 хэрэглэгчийн эрхтэй Microsoft office 365 business програм хангамж нийлүүлэх МО-2017/02 дугаартай тендер**

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А-24 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хороо 2017 оны 2 дугаар сарын 8-ны өдөр Монголбанкинд 250 хэрэглэгчийн эрхтэй Microsoft office 365 business програм хангамж нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 3 дугаар сарын 10-ны өдөр хүлээж авсан. Үнэлгээний хороо тендерт оролцогчдын ирүүлсэн тендерийг хуулийн дагуу судалж үзээд, “Инфосолюшн” ХХК-ний ирүүлсэн тендерийг “хамгийн сайн үнэлэгдсэн” тендерээ шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгож зөвлөмжийг хүргүүлсэн. Монголбанк “Инфосолюшн” ХХК-тай 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр 0217/258 тоот дугаар бүхий 250 хэрэглэгчийн эрхтэй Microsoft office 365 business програм хангамж

байгуулснаар “Инфосолюшн” ХХК 250 хэрэглэгчийн Microsoft office програм хүлээлгэн өгсөн.

2. Монголбанкинд зөөврийн болон ширээний компьютер нийлүүлэх КО-2017/03 дугаартай тендер

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А-54 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хороо 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Монголбанкинд зөөврийн болон ширээний компьютер нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 03 дугаар сарын 27-ны өдөр хүлээж авсан. Үнэлгээний хороо тендерт оролцогчдын ирүүлсэн тендерийн материалыг хуулийн дагуу судалж үзээд, Багц 2-т “Саммит компьютер технологи” ХХК-ний ирүүлсэн тендерийг “хамгийн сайн үнэлэгдсэн” тендерээр шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгож, зөвлөмжийг хүргүүлсэн. Монголбанк “Саммит компьютер технологи” ХХК-тай 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 0217/311 дугаар бүхий Монголбанкинд ширээний компьютер нийлүүлэх гэрээг байгуулсан. “Саммит компьютер технологи” ХХК 38 ширхэг компьютерыг хүлээлгэн өгсөн.

3. Монголын арилжааны банкуудын төлбөрийн чадварын үнэлгээ хийх зөвлөхийг сонгон шалгаруулах Cons 01/2017 дугаартай тендер

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн А-99 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хороо 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр зөвлөх үйлчилгээний тендерийн урилгыг өдөр тутмын сонин, Монголбанкны цахим хуудас болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байршуулсан. Тендерийн урилгын дагуу Mazars, PwC, KPMG, Deloitte, ИТСВ, Oliver Wyman, Black Rock гэсэн 7 зөвлөх компаниас оролцох сонирхлоо ирүүлснээс Deloitte, ИТСВ зөвлөх компаниуд хураангуй жагсаалтад орж чадаагүй бөгөөд үлдсэн 5 зөвлөх компаниудад саналын урилга хүргүүлсэн. Тус урилгын хариуд Mazars, PwC, KPMG, Oliver Wyman гэсэн 4 зөвлөхөөс тендерийн материал ирүүлснийг Үнэлгээний хороо хуулийн дагуу судалж үзэж байна.

4. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Монголбанкны “Б” байрны дээврийг шинэчлэх ажлыг гүйцэтгэх тендер шалгаруулалт А-2017/2 дугаартай тендер

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 4 дүгээр сарын 27-ний өдрийн А-135 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. 2017 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Монголбанкны “Б” байрны дээврийг шинэчлэх ажлыг гүйцэтгэх нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 6 дугаар сарын 27 –ны өдөр хүлээж авсан. Үнэлгээний хороо тендерт оролцогчдын ирүүлсэн тендерийг хуулийн дагуу судалж үзээд “Хүслэн Дэлгэрэх” ХХК-ний ирүүлсэн тендер нь “хамгийн сайн үнэлэгдсэн” тендерээр шалгараагүй гэж үзсэн. Үүний дагуу Монголбанкны “Б” байрны дээврийг шинэчлэх тендерийг дахин зарлахаар шийдвэрлэсэн.

5. Монголбанкинд зөөврийн компьютер нийлүүлэх Б-2017/01 дугаартай тендер

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн А-134 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хороо 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Монголбанкинд зөөврийн компьютер нийлүүлэх хязгаарлагдмал тендер шалгаруулалтыг зарлаж, 7 дугаар сарын 5-ны өдөр хүлээж авахаар ажиллаж байна.

сарын 19-ний өдөр Монголбанкинд зөөврийн компьютер нийлүүлэх хязгаарлагдмал тендер шалгаруулалтыг зарлаж, 7 дугаар сарын 5-ны өдөр хүлээж авахаар ажиллаж байна.

### **Хоёр. Харьцуулалтын аргаар худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тухай**

Тамгын газрын 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 59 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан байна. Гэрээ байгуулахад компанийн саналыг хууль, журмын дагуу харьцуулан судалж, чанар, үнэ, нийлүүлэх хугацаа, баталгаат хугацаа, туршлага болон бусад нөхцөл шалгуурыг хянасны үндсэн дээр гэрээний төслийг боловсруулж, Хууль эрх зүйн газраар хянуулж, холбогдох албан тушаалтнаар батлуулдаг.

Тайлант хугацаанд байгуулагдсан 59 гэрээг төрлөөр нь ангилан үзвэл:

1. Худалдах, худалдан авах гэрээ – 24
2. Ажил гүйцэтгэх гэрээ - 19
3. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ -2
4. Хамтран ажиллах гэрээ - 2
5. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ - 4
6. Даатгалын гэрээ -3
7. Барилгын эскиз зураг төслийн ажил гүйцэтгэх гэрээ -1
8. Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх ажлын гэрээ - 1
9. Үйлчилгээ үзүүлэх гэрээ -3

Гэрээ дүгнэсэн болон бараа хүлээлцсэн актыг гэрээний материалд хавсарган, гэрээний биелэлтэд тухай бүр хяналт тавьж ажиллаж байна.